



## МОНГОЛБАНКНААС СЭТГҮҮЛЧДИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ “ШИЛДЭГ ЭДИЙН ЗАСГИЙН НИЙТЛЭЛ” УРАЛДААНЫ УДИРДАМЖ

### НЭГ. СЭДЭВ: “ТӨВ БАНК БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ”

Дэлхийн ихэнх улс орнуудад төрийн мөнгөний бодлогыг Төв банкнаас хэрэгжүүлдэг. Төв банкууд нь нэг эсвэл хэд хэдэн тодорхой зорилтыг биелүүлэхийн төлөө ажилладаг бөгөөд, тэдгээр нь инфляци, ажилгүйдэл, ханш, эдийн засгийн өсөлт, санхүүгийн тогтвортой байдал г.м. байх нь түгээмэл. Тэгвэл Төв банк эдийн засгийн өсөлтийг зорилтоо болгох үед үүсдэг эерэг болон сөрөг талуудын талаар эмхэтгэн дүгнэж, тодорхой жишээгээр тайлбарлан бичнэ үү.

### ХОЁР. НИЙТЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✓ Нийтлэлийг 800-1000 үгэнд багтаан бичих;
- ✓ Судалгаа, тоо баримттай байх;
- ✓ Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- ✓ Нийтлэл бичих ерөнхий бүтцийг баримталсан байх;
- ✓ Бусдын бүтээлийг хуулбарлаагүй байх;
- ✓ Нийтлэлийн бичгийн стандарт:
  - Үсгийн фонд: Times New Roman;
  - Үсгийн хэмжээ: 12;
  - Мөр хоорондын зай: 1,5;
  - Margins: top 2 cm, bottom 2 cm, left 3 cm, right 1.5 cm.
- ✓ Нүүр хуудсанд өөрийн овог нэр, ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагын нэр, холбоо барих 2 утас, и-мэйл хаягыг бичих.

### ГУРАВ. ШАЛГАРУУЛАЛТ

- ✓ Нийтлэлд тавигдаж буй шаардлагыг хангасан, өгөгдсөн сэдвийн хүрээнд бодит мэдээллийг ашиглаж, баримтаар баталгаажуулсан, энгийн ойлгомжтой, сонирхолтой байдлаар бичигдсэн эсэхийг харгалзан эхний 3 байрын эздийг тодруулна.
- ✓ Нийтлэлийн уралдааны дүнг **2017 оны 3 дугаар сарын 24**-нд зарлаж, шалгарсан оролцогчдод өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулна.
  - I байр: 300,000 төгрөг
  - II байр: 150,000 төгрөг
  - III байр: 100,000 төгрөг
- ✓ **Хугацаа:** Уралдаанд оролцох бүтээлийг **2017 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 18.00 цаг хүртэл** цахим хэлбэрээр [communication@mongolbank.mn](mailto:communication@mongolbank.mn) хаягаар, хэвлэмэл хувийг Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвд хүлээн авна.

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “Б” байр  
Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв  
МОНГОЛБАНК**

Дэлгэрэнгүй мэдээллийг [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn) веб хуудаснаас  
болон (976) 11-310081 утсаар лавлана уу.